



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 7/545

Арвайхээр сум

**Төв суурин газрын 2023-2024 оны өвөлжилтийн
бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.15, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төв суурин газрын 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл Ажлыг хангах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Б.Мөнхбат (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Т.Ариунболд (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Б.Дэмбэрэлсайхан (“ЭБЦТС” ТӨХК-ийн Өвөрхангай аймаг дахь салбарын захирал)

М.Жамъяншарав (“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ийн Өвөрхангай аймаг дахь газрын дарга)

Д.Лхам-Оролмаа (Өвөрхангай АЗЗА ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал)

Ч.Ганхуяг (“Баянтээг”ХК-ийн Гүйцэтгэх захирал)

Ц.Хоролсүрэн (“Онги Ус Суваг” ОНӨААТҮГ-ын Гүйцэтгэх захирал)

Б.Хонгорзул (“ЦДҮС ТӨХК Хангай бүсийн салбарын Арвайхээр дэд станцын Ашиглалтын инженер)

Д.Алтансүвд (аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Орон тооны гишүүн)

Сумдын Засаг дарга нар

6223 11 1095

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Нарийн бичгийн дарга: О.Төмөрчөдөр (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

2.Төв, суурин газрын 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг гарган батлуулах, холбогдох арга хэмжээ авч, үр дүнг тайлагнаж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Б.Мөнхбат)-д даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН